- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ-т дээд шатны байгууллагаас хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хийгдээгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ-т дээд шатны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 7,808.1 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 156.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,498.0 сая төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	145,026.9	431,164.7	286,137.8
Авлага	128,651.9	69,845.7	(58,806.2)
Урьдчилгаа	12,045.0	7,026.4	(5,018.6)
Бараа материал	2,242,114.3	2,072,789.7	(169,324.6)
Үндсэн хөрөнгө	79,182,543.5	77,631,434.2	(1,551,109.3)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>81,710,381.6</b>	<b>80,212,260.7</b>	<b>(1,498,120.9)</b>
Өр төлбөр	6,215.3	9,667.8	3,452.5
Урьдчилж орсон орлого	12,958.2	-	(12,958.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	81,691,208.1	80,202,592.9	(1,488,615.2)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>81,710,381.6</b>	<b>80,212,260.7</b>	<b>(1,498,120.9)</b>



Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 431.2 сая төгрөг болж 288.2 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор зардлуудыг хэмнэсэн;
- Авлагын дансны үлдэгдэл 58.8 сая төгрөгөөр буурсан нь төлбөртэй үйлчилгээний авлагаа барагдуулсан;
- Бараа материалын данс нь Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газраас өгсөн хандив болон худалдан авалтаар нийт 791.2 сая төгрөгөөр нэмэгдэж, 960,5 сая төгрөгийн бараа материал зарцуулсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 77,631.4 сая төгрөг болж 1,551.1 сая төгрөгөөр буурсан нь захирлын 2021 оны А/22, 31, 34 дүгээр хөрөнгө шилжүүлэх тушаалаар 438.3 сая, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 591, 2021 оны А-1/2111 дүгээр тогтоолоор нийт 163.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассантай холбоотой.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд 2021 оны төсвийг 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,645.3 сая төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогыг 730.3 сая төгрөг, нийт 7,375.6 сая төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,110.0 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 691.1 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого 4.4 сая төгрөг, нийт 5,805.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 5,519.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

*Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71301	Харилцаа холбооны зохицуулалт	7,375,590.9	5,805,469.4	1,570,121.5	78.7
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	7,061,710.9	5,225,336.4	1,836,374.5	74.8
1.2	80918	Хөрөнгийн зардал	313,880.0	293,829.4	20,050.6	93.6

Үндсэн үйл ажиллагааны орлого төлөвлөгөөнөөс 39.2 сая төгрөгөөр буурсан нь шугамын радиогийн төлбөрийг ОСНААУГ-тай гэрээ байгуулан айл өрхүүдийн орон сууцны төлбөртэй хамт суутган авч шилжүүлэх гэрээтэй ажилладаг ба коронавирусын цар тахал гарсантай холбоотойгоор Засгийн газрын 2020 оны 12 сарын 13-ны өдрийн 211 тоот тогтоолоор айл өрхүүдийн орон сууцны төлбөрийг хөнгөлсөн ба шугамын радиогийн төлбөр тэглэгдэн тасарсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,519.2 сая төгрөг буюу 74.8 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардал 1,743.8 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг 92.6 сая төгрөг, хөрөнгийн зардал 20.1 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ-ын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 2 арга хэмжээний хэрэгжилт 78.7 хувь, хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 74.8 хувийн биелэлттэй, 24.6 хувиар зөрүүтэй буюу төсвийг хэмнэлттэй зарцуулж, байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага 2021 онд цамхгийн их биед ядралын зэрэг тогтоож урсгал засвар хийх 2020 оны 3 дугаар сарын 26-ны ТД-3/2020 тоот захирлын тушаалаар сайжруулалтын ажил хийсэн байна. Тус байгууллагын хөрөнгөнд бүртгэлгүй Булган Дашинчилэн цамхаг, Шархад цамхгийг будаж урсгал засвар хийсэн ба эдгээр цамхгийг цаашид өөрийн бүртгэлд авах талаар арга хэмжээг авах шаардлагатай байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 81.3 сая төгрөгийн ажил гүйлгээний мэдээллийг илүү байршуулсан ба 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй Ерөнхий нягтлан бодогчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд сургалт, семинар, хурал зөвлөгөөн, баяр ёслолд зориулж 10.8 сая төгрөгийн зардал гаргаж хэмнэлт гаргаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх", 1.6. "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 893.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад зөвлөмжийг хэрэгжүүлсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага биелэлт 90 хувь, 61.0 сая төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 95 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	57,500.0	1	57,500.0			90
Зөвлөмж	4	61,000.0	4	61,000.0			95
Нийт дүн	5	118,500.0	5	118,500.0			92.5

Шилэн дансны цахим сайтад мэдээллийг бүрэн хугацаанд нь байршуулдаггүй, зөрчлийг давтан гаргасан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч авч үзэх асуудал байхгүй байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 79.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 57.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 79.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинээс 77.2 сая төгрөгөөр бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

##### 4.2 Албан шаардлага

Аж ахуй нэгж байгууллагуудаас худалдан авалт хийсэн 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй зардлыг түүвэрлэн тулган шалгахад 21.2 сая төгрөгийн цахим баримтыг аваагүй, баримтын бүрдлийг ханган ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6. “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалт хийхдээ бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас төлбөрийн цахим баримтыг гаргуулан авч байх, цахим төлбөрийн баримтын системд оруулсан эсэхэд хяналт тавьж хэвших, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

##### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 1. **Балансын данстай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 11-ний 4 тоот дугаартай хурлын шийдвэрээр актлах 28.6 сая төгрөгийн хангамжийн материалыг тайлант онд баланс тайлангаас хасч бүртгээгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2. “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана.” гэсэн заалттай нийцээгүй, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг тушаал шийдвэрийн дагуу хөрөнгийг актлан санхүүгийн тайланд тусгаж байх.

###### 2. **Балансын данстай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Бараа материалыг түүвэрлэн шалгахад 9.6 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, шаардах хуудсыг гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг зарлагадахдаа бүрдүүлэх анхан шатны баримтыг иж бүрэн хөтөлж гарын үсэг зурж баталгаажуулсны дараа бүртгэлийг хийх.

**3. Балансын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Авлага, өр төлбөрийн журналыг харилцагч байгууллага тус бүрээр хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 20.2.5, "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцээгүй, ангилал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дансны өглөг, авлага, төлбөрийн тооцоог харилцагч бүрээр журналд тусгаж үлдэгдэлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх.

**4. Балансын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Голден бэмби ХХК-ний торон хашаа сэргээж засах 19.5 сая төгрөгийн ажил үйлчилгээний баримтыг тулган шалгахад ажил хүлээн авсан актгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй, иж бүрэн, тасалбар болголт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, гэрээний дагуу гүйцэтгэлийг актаар хүлээн авч, гэрээг дүгнэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
						Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:															
1	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ	АХГ-2022/34/НА-СТА-ТӨА	Аж ахуй нэгж байгууллагуудаас худалдан авалт хийсэн 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй зардлыг түүвэрлэн тулган шалгахад 21.2 сая төгрөгийн цахим баримтыг аваагүй, баримтын бүрдлийг ханган ажиллаагүй байна	1	21,216.2							1	21,216.2		
2	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ	АХГ-2022/34/НА-СТА-ТӨА	Авлага, өр төлбөрийн журналыг харилцагч байгууллага тус бүрээр хөтлөөгүй байна	1	-									1	-
3	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ	АХГ-2022/34/НА-СТА-ТӨА	Бараа материалыг түүвэрлэн шалгахад анхан шатны баримтын бүрдэл дутуу шаардах хуудсыг гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.	1	9,629.6									1	9,629.6
4	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ	АХГ-2022/34/НА-СТА-ТӨА	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 11-ний 4 тоот дугаартай хурлын шийдвэрээр актлах хангамжийн материалыг тайлант онд баланс тайлангаас хасч бүртгээгүй байна.	1	28,660.6									1	28,660.6
5	Радио Телевизийн Үндэсний	АХГ-2022/34/НА-СТА-ТӨА	Голден бэмби ХХК-ний торон хашаа сэргээж засах ажил үйлчилгээний баримтыг тулган	1	19,500.0									1	19,500.0

Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	Сүлжээ УТҮГ		шалгахад ажил хүлээн авсан акт байхгүй байна.											
<b>Дүн</b>				<b>6</b>	<b>79,006.4</b>				<b>1</b>	<b>21,216.2</b>			<b>5</b>	<b>61,040.7</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:</b>														
1	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ	АХГ- 2022/34/ НА-СТА- ТӨА	Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 81.3 сая төгрөгийн ажил гүйлгээний мэдээллийг илүү байршуулсан ба 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна	1	-				1	-	1	-		
2	Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ	АХГ- 2022/34/ НА-СТА- ТӨА	Тайлант онд сургалт, семинар, хурал зөвлөгөөн, баяр ёслолд зориулж 10.8 сая төгрөгийн зардал гаргаж хэмнэлт гаргаагүй байна	1	10,819.4				1	10,819.4				
<b>Дүн</b>				<b>2</b>					<b>2</b>	<b>52,909.4</b>				
<b>Нийт дүн</b>				<b>8</b>	<b>89,825.8</b>				<b>3</b>	<b>28,785.1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>61,040.7</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 327/А0150054

Улаанбаатар хот

АХГ-2022/34/НХ-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Радио, Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Радио, Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ нь аж ахуй нэгж, байгууллагуудаас 21,216,185.98 төгрөгийн худалдан авалтын цахим баримтыг аваагүй, баримтын бүрдлийг ханган ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан татвар шаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалт бүрд бэлтгэн нийлүүлэгчдээс цахим төлбөрийн баримтыг авч байх, төлбөрийг цахим системд оруулсан эсэхэд хяналт тавьж хэвших, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Радио, Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ-ын захирал С.Цагаанхүү, ерөнхий нягтлан бодогч Б.Батмөнх нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Т.ГҮНЖИДМАА  
М.ЭНХТУУЛ

9056109  
9019120596

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0315\_Auditin\_2\_Gazar-7.Docx

0010800959





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 329/А0150054

Улаанбаатар хот

АХТ-2022/34/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Радио, Телевизийн Үндэсний Сүлжээ УТУГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд сургалт, семинар, хурал зөвлөгөөн, баяр ёслолд зориулж 10,819,350.00 төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх", 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан т/шаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Радио, Телевизийн Үндэсний Сүлжээ УТУГ-ын захирал С.Цагаанхүү, ерөнхий нягтлан бодогч Б.Батмөнх нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХӨӨРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Т.ГҮНЖИДМАА  
М.ЭНХТУУЛ

9006109  
9019120396

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-764230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-5.Docx

0010800955



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 328/AD150054

Улаанбаатар хот

АХГ-2022/34/НА-СТА-ТӨА

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Радио, Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 81,288,068.53 төгрөгийн ажил, гүйлгээний мэдээллийг илүү байршуулсан ба 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулан зөрчлийг давтан гаргаж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлэх журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Радио, Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ-ын ерөнхий нягтлан бодогч Б.Батмөнхөд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг захирал С.Цагаанхүүд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА  
М.ЭНХТУУЛ

